

“CHULUUT SKY VILLA CUP 2024 – INTERNATIONAL GOLF TOURNAMENT” ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

ТАЛБАЙ: Богд уулын гольфийн талбай (Mt.Bogd Golf Course)

ОГНОО: 06-р сарын 14-16-ны хооронд

ТЭМЦЭЭНИЙ ЕРӨНХИЙ СПОНСОР: “Chuluut Sky Villa”

ЗОХИОН БАЙГУУЛАЛТ: Тэмцээний ерөнхий зохион байгуулагтыг Монголын Гольфийн Холбоо хариуцана. Үүнээс хойш тэмцээн зохион байгуулагчийг тэмцээний хороо гэнэ. Тус тэмцээнд оролцох тоглогчдын тооны хязгаар болон “Local Rule”-ийг тогтооно. Тус хорооны аливаа шийдвэр үл маргах журмаар эцсийнх байна. Тус тэмцээн нь “Strokeplay format”-р хийгдэж “Medalist” ялагчийг тодорхойлох бөгөөд “Sponsor’s Handicap”-н төрлийн тэмцээн зэрэг явагдана.

ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Тэмцээнд R&A-ийн хамгийн сүүлийн дүрэм, шийдвэрүүд, хорооноос тогтоосон “local rule”-ийг мөрдөнө.
2. Тэмцээнд нийт 80 эрэгтэй тоглогч оролцоно. Тэмцээнд оролцох болзол хангахын тулд Монголын Гольфийн Холбооны албан ёсны Хандикаптай байх болон ерөнхий спонсорын урилгаар оролцох боломжтой.
3. Тэмцээнд Монголын Гольфийн Холбооны чансааны жагсаалтын эхний 60 тоглогч шууд оролцох боломжтой. Үлдсэн 20 тоглогчийг нээлттэй бүртгэлээр бүрдүүлнэ.
4. МГХ-ны 2024 оны албан хандикап бүртгэлгүй тоглогч нар “World Handicap System”-с олгогдсон албан хандикаптай бол тэмцээний 200,000₮ хураамж төлөөд оролцох боломжтой.
5. Хороо оролцогчийг шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тэмцээнд оролцуулахаас татгалзах эрхтэй.

ТЭМЦЭЭНИЙ БҮРТГЭЛ

1. 2024 оны 6 дугаар сарын 11-ний өдөр тэмцээний нээлттэй бүртгэл хийгдэнэ.

ФЛАЙТ ХУВААРИЛАЛТ, ЭХЛЭХ ЦАГ, НҮХ

1. Хороо тэмцээний өмнөх өдөр флайт хувиарлалт, эхлэх нүхийг урьдчилан гаргаж зарлана. Урьдчилан зарласан флайтын хувиарлалт, эхлэх цаг зэрэгт аливаа өөрчлөлт хийхийг хориглоно.
2. Шаардлагатай тохиолдолд хороо флайт хувиарлалт, эхлэх цагийг тэмцээн эхлэхээс өмнө өөрчлөх эрхтэй.

3. Тоглогч эхлэх нүхэнд эхлэх цагаас дор хаяж 5 минутын өмнө очиж бэлтгэлээ хангасан байна. Эхлэх цагаас 5 хүртлэх минут хоцорвол “Penalty Rule 6-3a” дүрмийн дагуу 2 онооны торгууль ноогдуулж тухайн тоглогчийн эхний нүхний оноон дээр нэмнэ. 5-с дээш минут хоцорсон тохиолдолд тэмцээнээс хасна.
4. Хороо тэмцээний тийний байршил тэмцээн болох тухайн өдөр тоглогч нарт танилцуулна.

ТЭМЦЭЭНИЙ АВАРГА ШАЛГАРУУЛАХ

1. Тэмцээний аваргыг 54 нүхний нийлбэр дүнгээр хамгийн бага онооны дүрмээр шалгаруулна. Хэрэв аваргын төлөө өрсөлдөөнд тэнцсэн тохиолдолд тэдгээр тоглогч нар 18 ба 9-р нүх гэсэн дарааллаар хасагдах (sudden death) журмаар “play-off” тоглолт хийнэ. Тэмцээний бусад шагналт байрны төлөөх өрсөлдөөнд тэнцсэн тохиолдолд дараах дарааллаар ялагчийг тодруулна.
 - i. Сүүлийн 18 нүх
 - ii. Сүүлийн 9 нүх
 - iii. Сүүлийн 6 нүх
 - iv. Сүүлийн 3 нүх
 - v. Сүүлийн 2 нүх
2. Хандикапын ангилалын ялагчийг тодруулахдаа нийт онооноос талбайн оноог хассан ялгавараас тоглолтын хандикапыг хасч хамгийн багаас их рүү эрэмбэлж шалгаруулна. Хандикапын шагналын өрсөлдөөнд тэнцсэн тохиолдолд дараах дарааллаар ялагчийг тодруулна.
 - i. Сүүлийн 18-р нүхний оноо
 - ii. Сүүлийн 9 нүх
 - iii. Сүүлийн 6 нүх
 - iv. Сүүлийн 3 нүх
 - v. Сүүлийн 2 нүх

ТЭМЦЭЭНИЙГ ДУУСГАХ

Тэмцээний ялагч, шагналт байранд шалгарсан тоглогч нарт цом, бай шагналуудыг гардуулснаар, эсвэл хороо дуусгах тухай шийдвэр гаргаснаар тэмцээн албан ёсоор дууссанд тооцно.

ДҮРМИЙГ ТАЙЛБАРЛАХ

1. Хороо дүрмийг тайлбарлах, шийдвэр гаргах бүрэн эрх эдлэнэ.
2. Дүрмийн маргаантай асуудал үүссэн тохиолдолд нийт 2 албан ёсны шүүгчдийн нэгийг дуудаж тухайн дүрмийн маргаантай газраа шийдвэрлүүлэх боломжтой.
3. Дүрмийн маргаантай асуудал үүсээд тэмцээний шүүгчдээс очиж маргааныг шийдвэрлэх боломжгүй тохиолдолд 20.1с(3) дүрмийн дагуу оноо хөтөлж буй тоглогчдоо мэдэгдээд хоёр бөмбөгөөр тухайн нүхээ тоглож дуусгаад тэмцээний дараа онооны хуудас дээр гарын үсэг зурахаас өмнө тэмцээний хороогоор шийдвэрлүүлээд зөв оноогоо бичээд гараа үсгээ зурна.

ТОГЛОЛТЫН ЦАГ БАРИМТЛАХ, УДААН ТОГЛОХ

Гольфийн дүрмийн (R&A) 6-7 заалтуудад заасны дагуу тоглолтын хурдыг тоглогч бүр мөрдөх үүрэгтэй. 18 нүхэнд тоглож дуусгах таамаг дээд хугацаа 5 цаг байна.

Тоглолтын хэмнэл баримтлах (R&A дүрмийн 6-7)

Хэрэв хамгийн эхэнд гарсан флайт тоглолтын явцад нийт тоглосон нүхэнд ноогдох зөвшөөрөгдсөн таамаг хугацаанаас удаан хэмнэлтэй байвал эхний флайтыг хурд удааширсан флайт гэж үзнэ. Дараа дараагийн флайтуудыг дараах нөхцөлд хурд удааширсан флайт гэж тодорхойлно. Үүнд:

- a. Зөвшөөрөгдсөн таамаг хугацаанаас удаан хэмнэлтэй байвал
- b. Пар 3 нүхний эхлэлийн цэг дээр ирэх үед өмнөх флайт дараагийн нүхний эхлэлийн цэгийг (tee box) орхин явсан байвал, Пар 4 нүхний эхлэлийн цэгийг орхин яваагүй байхад өмнөх флайт грийнийг орхин явсан байвал, Пар 5 нүхний эхлэлийн цэг дээр очоогүй байхад өмнөх флайт грийн дээр очсон байвал хурд удааширсан флайт үзнэ.

Хурд удааширсан флайтад дараах арга хэмжээ авна. Маршал эсвэл тэмцээний ерөнхий шүүгч тухайн флайтын хурд удааширсан шалтгааныг (бөмбөг хайсан, unplayable ball, буруу бөмбөгөөр тоголсон гэх мэт) авч үзээд цаг хэмжих шаардлагатай эсэх шийдвэр гаргана. Хэрэв цаг хэмжих шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тухайн флайт дахь тоглогч бүрийн тоглолтын цагийг хэмжих ба хурд удааширсан флайтаар тодорхойлогдсоныг флайтын тоглогч бүрд мэдэгдэж торгуулийн талаар сануулна.

Нэг цохилтыг гүйцэтгэх хамгийн дээд хугацаа 40 секунд байна. Гэвч дараах тохиолдолуудад нэмэлт 10 секундын хугацаа олгоно. Үүнд:

- a. Пар 3 нүхний эхний цохилт
- b. Пар 4 эсвэл 5-ийн 2 дахь цохилт
- c. Бүх нүхний грийний хажуугаас хийх цохилт эсвэл патт хийх үед

Тоглогчийн тоглолтын цагийг хэмжихдээ тоглогч бөмбөг дээрээ ирсэнээс хойш эхлүүлэх ба цохилт гүйцэтгэхэд гадны ямар нэг саад, нөлөө байхгүй байх ёстой. Грийн дээрх тоглолтыг хэмжихэд тоглогчид ball mark засах, паттлах лайнаас саадыг зайлуулах хэдэн секунд нэмж болно. Флайтын тоглолтын хэмнэл зөвшөөрөгдсөн хугацаанд эргэн орсон эсвэл өмнөх флайтыг дагах зохистой байрлалд шилжсэн тохиолдолд хугацаа хэмжилтийг зогсооно. Хэрэв хэмжилтийн явцад аль нэг тоглогч зөвшөөрөгдсөнөөс удаан хугацаанд цохилт гүйцэтгэсэн бол тэрхүү тоглогчийг “удаан” гэж үзнэ.

Нүх тус бүрийг тоглох таамаг хугацааг тоглогч бүрд урьдчилан мэдэгдэх ба таамаг хугацаанаас хоцроогүй флайтыг “удаан” гэж үзэхгүй.

Тоглолтын хэмнэл алдсаны торгууль

- i.1 удаа “удаан” гэж тодорхойлсон тоглогчид сануулга өгч дараагийн удаа торгууль ногдуулах болохыг мэдэгдэнэ
- ii.2 удаа “удаан” гэж тодорхойлсон тоглогчийг 1 оноогоор торгоно.
- iii. Дахин “удаан” гэж тодорхойлсон тоглогчийг тэмцээнээс хасч талбай чөлөөлөхийг шаардана.

ЗӨВШӨӨРӨГДСӨН БӨМБӨГ

R&A дүрмийн 3 дугаар хавсралтад заасан бөмбөгийг тэмцээнд ашиглахыг зөвшөөрнө. Хэрэв зөвшөөрөгдөөгүй бөмбөгөөр тоглосон бол тэмцээнээс хасна.

ЗӨВШӨӨРӨГДСӨН DRIVER-ИЙН ТОЛГОЙ

R&A-с зөвшөөрсөн “driver”-н толгой ашиглах ба зөрчсөн тохиолдолд тогосон нүх бүрд 2 оноогоор торгоно. Нэг тоглогчид ногдуулах торгуулийн оноо 4-с хэтрэхгүй байна. Зөвшөөрөгдөөгүй “driver”-н толгой ашигласан нь тодорхой болсон бол тэрхүү цохиурыг тус тэмцээний турш дахин ашиглаж болохгүй. Хэрэв мэдсээр байж дахин ашигласан тохиолдолд тэмцээнээс хасна.

RANGEFINDER

4.3а (1) дүрмийн дагуу зай хэмжих төхөөрөмж нь зөвшөөрөгдсөн. Харин тухайн төхөөрөмж нь налуу хэмжих тохиргоогүй юмуу тус тохиргоог нь унтраасан байх шаардлагатай.

LOCAL RULE

3, 4, 5, 9, 11, 12, 15-р нүхэнд торгуультай хэсгээс релиф авах бол заавал тусгайлан тэмдэглэсэн Дроп хэсэгт дроплоно. 9-р нүхэнд бөмбөг зөвхөн гүүрний баруун өнцгөөс баруун гар талаар торгуультай хэсгийн шугам давсан тохиолдолд урд Дроп хэсэгт дроплоно.

- Тухайн нүхэнд бөмбөг орсноор нүхний тоглолт дуусна. (Concede байхгүй)

ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

Шагнал	Медалист	Хандикап
1-р байр	Цом, Алтан медаль	1-р байр- Цом, Алтан медаль
2-р байр	2-р байр- Цом, Мөнгөн Медаль	2-р байр- Мөнгөн Медаль
3-р байр	3-р байр- Цом, Хүрэл Медаль	3-р байр- Хүрэл Медаль

Медалистийн төрөлд шагналт байр эзэлсэн тоглогчид Хандикапын төрөлд шагнал давхардуулан олгохгүй. Монголын Гольфийн Холбооны Дэлхийн хандикапын системийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн хандикап бүртгэлгүй оролцогч хандикапын ангилалын шагналд хамрагдахгүй.

КАРТ, ТЭРЭГ/ КЭДДИ

1. Хоёр тоглогч дундаа нэг карт/тэрэг ашиглана. Хоёр тоглогчийн дунд 1 кэдди туслах учир каддитэй холбоотой торгууль ноогдуулахгүй.

ТЭМЦЭЭНИЙ ДАРААХ ХҮЛЭЭН АВАЛТ

Тэмцээний хүлээн авалт болон шагнал гардуулах үйл ажиллагаа нь Ерөнхий спонсорын “Chuluut Sky Villa” хотхонд 6-р сарын 16-ны 16:00 цагаас хийгдэнэ.

-----oO-----